



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/599

Арвайхээр

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн а/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.3, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргад хандан тусламж хүсэж өргөдөл ирүүлсэн хүнд өвчтэй, өрхийн орлогогүй зэрэг нэр бүхий 8 иргэнд нийт 3,700,000 (гурван сая долоон зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101259

Аймгийн Засаг даргын 2021 оны 18
дугаар сарын 03-ны өдрийн 4/599
дугаар захирамжийн хавсралт



НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ
ИРГЭДИЙН НЭРС

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суугаа хаяг	Мөнгөн дүн
1.	Д.Отгонбаяр	ЙЮ50122564	Арвайхээр сум 3 дугаар баг, 1 дүгээр гудамж, 08 тоот	300,000
2.	С.Төмөрбаатар	СИ49100418	Арвайхээр сум 7 дугаар баг, 32 гудамж 05 тоот	200,000
3.	С.Бумхорол	ЙЖ74082011	Гучин-Ус сумын 1 дүгээр баг	300,000
4.	Д.Пүрэвжав	ТК75090904	Арвайхээр сум 9 дүгээр баг 29 гудамж 15 тоот	200,000
5.	С.Наранчимэг	ЙС73032626	Арвайхээр сум 6 дугаар баг 21 гудамж 04 тоот	200,000
6.	Т.Болортөгс	ЙЮ03312904	Арвайхээр сум 2 дугаар баг 29 гудамж 09 тоот	500,000
7.	Д.Ичинхорлоо	ЙЖ95102202	Арвайхээр сум 9 баг 8 дугаар гудамж 01 тоот	1,000,000
8.	Ц.Эрдэнэбаатар	ЙЮ61111771	Арвайхээр сум 6 дугаар баг гудамж 6-6 тоот	1,000,000
Нийт дүн			3,700,000	

-оОо -